



УУЛ УУРХАЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ИНДЕКС /туршилтын хувилбар/

2.2	УУХОБИ-ийн ерөнхий индекс
2.1	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын орчин
2.6	Байгаль хамгааллын бодлогын орчин
2.3	Татварын бодлогын орчин
2.2	Нутгийн уугуул иргэдийн аж байдлын бодлогын орчин

Зорилго: Төр засгийн зүгээс уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын талаарх бодлого, шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлтийг тогтмол үзүүлэлтээр хэмжиж хөндлөнгийн мэдээллээр оролцогч талуудыг хангахад индексийн зорилго оршино.

Индекс: Нүүрс, алт, зэсийн олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг салбарын топ компаниудын удирдах албан тушаалтнуудаас судалгааны мэдээлэл цуглуулж, тэдгээрийн санал бодол дээр үндэслэн туршилтын индексийг боловсруулав.

Цаашид салбарын топ компаниудын удирдах албан тушаалтнаас улирал тутамд мэдээлэл цуглуулж, мэдээллийн санг бүрдүүлэхээр зорин ажиллаж байна. Ингэснээр зорилтот албан тушаалтны бодлогын орчны талаарх байр суурийг тодорхой давтамжтайгаар тодорхойлох боломж бүрдэхийн сацуу бодлогын үр нөлөөг харьцуулах боломжтой болно.

Уул уурхайн хөрөнгө оруулалтын бодлогын индексийг улиралд 1 удаа тооцож, олон нийтэд зарлана. Индексийн туршилтын хувилбар нь 2017 оны 09 сараас 11 сарын хоорондох хугацааг хамарсан. Уул уурхайн хөрөнгө оруулалтын бодлогын индексийг улиралд 1 удаа тооцож, олон нийтэд танилцуулахаар төлөвлөж байна.

УУХОБИ-ийг нийт 9 үзүүлэлтээр үнэлсэн. Үүнд:

УИХ, Засгийн Газар, Орон нутгийн удирдлагын уул уурхайн хөрөнгө оруулалтын чиглэлээр гүйцэтгэж буй ажил

Уул уурхайн салбар дахь ажлын байр, татвар, дэд бүтцийн талаар баримталж буй бодлогын орчин

Уул уурхайн салбар дахь байгаль орчны хамгаалал, нутгийн уугуул иргэдийн аж байдлын талаар баримталж буй бодлогын орчин
Уул уурхайн салбар дахь авилгын эрсдэлийн үнэлгээ

Уул уурхайн хөрөнгө оруулалтын бодлогын ерөнхий индекс
авбал зохих 5 онооноос 2,2 оноо авч дундаас доогуур үнэлэгдлээ.

УУХОБИ-ийг бүрдүүлэгч үзүүлэлт тус бүрээр нь авч үзвэл уул уурхайн салбар дахь ажлын байр болон байгаль хамгааллын талаар баримталж буй бодлого гэсэн үзүүлэлтүүд авбал зохих онооны 50 хувиас дээгүүр гарсан бол УИХ, Орон нутгийн удирдлага, ЗГ-ын уул уурхайн хөрөнгө оруулалтын чиглэлээр гүйцэтгэж буй ажил болон авилгын эрсдэл гэсэн үзүүлэлтүүд авбал зохих онооны 50 хувьд хүрч чадаагүй байна





Судалгаанд оролцогчид уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтад саад болж буй хүчин зүйлсийг нэрлэж байна.

